<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12210000.00</b>	<b>1840000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	12210000.00	1840000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12210000.00	1840000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	154068147.00	142848097.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	154068147.00	142848097.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39947850.00	115711672.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100664297.00	16247385.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13456000.00	10889040.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сайхан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Л.Пүрэвсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 09-нөөс 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Сайхан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланга Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/53 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сайхан сумын Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны эрхэм зорилго, зорилтыг нарийвчлан тодорхойлоогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сайхан сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайланд 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 3211.8 сая төгрөгийн 2 хувь буюу 64.2 сая төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 102.1 сая, эцсийн үлдэгдэл 162.9 сая төгрөг болж, 73.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Төрийн сангийн харилцах	90.84	164.71	73.87	100%
Арилжааны банкин дахь харилцах	0.10	0.00	-0.10	0%
<b>Дүн</b>	<b>90.94</b>	<b>164.71</b>	<b>73.77</b>	<b>100%</b>

#### Үүнээс байгууллагын төрлөөр

Төсөвт байгууллага	36.15	112.91	76.76	68.6%
Төсөл/сан			0.00	0.0%
Төрийн сан	54.69	51.80	-2.89	31.4%
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.10		-0.10	0.0%
<b>Дүн</b>	<b>90.9</b>	<b>164.7</b>	<b>73.8</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Сайхан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа БХС-гийн 1.7 сая, ЖДҮДС-гийн 9.1 сая, СХС-гийн 72.7 сая, ОНӨО 59.9 сая, ОНХС-гийн 19.5 нийт 162.9 сая төгрөг буюу төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө, хадгаламж дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд үлдэгдэлгүй байна

#### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 325.0 сая, эцсийн үлдэгдэл 286.6 сая төгрөг болж, 38.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Ажиллагчидтай холбогдсон авлага		0.064	0.064	0%
Байгууллагаас авах авлага	13.05	9.055	-3.993	3%
Хувь хүнээс авах авлага	312.00	277.512	-34.483	97%
<b>Дүн</b>	<b>325.04</b>	<b>286.63</b>	<b>-38.41</b>	<b>100%</b>

#### Үүнээс байгууллагын төрлөөр

Засаг даргын тамгын газар	14.92	8.56	-6.359	3.0%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал		0.05	0.053	0.0%
Сум хөгжүүлэх сан	304.20	271.54	-32.662	94.7%
Хүн эмнэлэг	0.35	0.49	0.138	0.2%
Цэцэрлэг		6.00	6	2.1%
Эргэлтийн эмийн сан	1.58		-1.581	0.0%

Орон нутгийн ерөнхий орлого		0	0.0%
Орон нутгийн хөгжлийн сан	4.00	-4	0.0%
<b>Дүн</b>	<b>325.04</b>	<b>286.63</b>	<b>-38.41</b>
			<b>100%</b>

Эх сурвалж: Сайхан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 6.2 сая төгрөгийн авлага нэмэгдэж, 2012-2019 оны насжилттай СХС, БХС-гийн 165.9 сая төгрөгийн авлага байна. Үүнд:

- СХС-гийн 2013-2019 оны 155.7 сая төгрөгийн зээл, мөн баг хөгжүүлэх сангийн 2012-2019 оны 10.2 сая төгрөгийн насжилт ихтэй авлага байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэж, харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Тухайлбал: Сургуулийн өмнөх боловсрол 6.0 сая төгрөг.
- Тайланд онд төсөвт байгууллагад 3.3 сая төгрөгийн авлага нэмэгдэж, СХС-гийн 2013-2019 оны 155.7 сая төгрөгийн зээл, мөн баг хөгжүүлэх сангийн 2012-2019 оны 10.2 сая төгрөгийн насжилт ихтэй авлага байна.

#### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэлгүй байна

#### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлгүй байна.

#### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 252.1 сая, эцсийн үлдэгдэл 191.7 сая төгрөг болж, 60.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эдлэх хувь
Тусгай зориулалттай материал	4.84	6.29	1.45	3.28%
Эм боох материал	19.15	12.35	-6.80	6.44%
Бэлэн бүтээгдэхүүн		0.41	0.41	0.21%
Бичиг хэргийн материал	4.35	4.86	0.52	2.54%
Аж ахуйн материал	131.77	133.83	2.06	69.82%
Сэлбэг хэрэгсэл	0.23	0.73	0.50	0.38%
Түлш шатах тослох материал		0.44	0.44	0.23%
Барилгын засварын материал			0.00	0.00%
Хүнсний материал	42.31	10.71	-31.59	5.59%
Бусад хангамжийн материал	45.41	18.00	-27.41	9.39%
Мал амьтад	4.06	4.06	0.00	2.12%
<b>Дүн</b>	<b>252.11</b>	<b>191.68</b>	<b>-60.43</b>	<b>97%</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр</b>				
Засаг даргын тамгын газар	60.28	34.44	-25.84	17.97%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3.18	3.15	-0.03	1.64%
Соёлын төв	6.60	5.57	-1.02	2.91%

Сургууль	92.16	68.12	-24.04	35.54%
Хүн эмнэлэг	27.96	33.78	5.82	17.62%
Цэцэрлэг	47.45	46.61	-0.84	24.32%
Эмийн эргэлтийн сан	14.48		-14.48	0.00%
Ингэт дөл			0.00	0.00%
<b>Дүн</b>	<b>252.11</b>	<b>191.68</b>	<b>-60.43</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Сайхан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 200.3, хандиваар 0.1, данс хооронд болон балансаас балансын хооронд шилжүүлэн авсан 1447.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 219.3, шилжүүлсэн 13.6, акталсан 43.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас тус тус хассан байна.

Бараа материалын тайлангийн үлдэгдэлд тайлант оны эцэст 191.7 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, эм боох материал, бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материалыг төсвийн хэмнэлтийг улс, орон нутгийн буцаан төсөвт төвлөрүүлэхгүй шалтгаанаар нөөцөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- + Бараа материалын ангиллыг буруу хөрөнгийн шинж чанартай зүйлийг бүртгэсэн УСНББОУС-12 ын дагуу зөв ангилж бүртгээгүй байна. Тухайлбал: СӨБ
- + Жилийн эцсийн тооллогоорх бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайланд илэрхийлээдсэн дүн, тодруулга тайлангийн дүн зөрүүтэй,. Тухайлбал: ЭМТ 5.6 сая төгрөг

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5153.9 сая, эцсийн үлдэгдэл 5083.4 сая төгрөг болж, 70.6 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	4,867.82	4,810.77	-57.05	95%
Хуримтлагдсан элэгдэл	-381.94	-575.90	-193.95	-11%
Авто-тээврийн хэрэгсэл	277.95	336.00	58.05	7%
Хуримтлагдсан элэгдэл	-208.61	-220.51	-11.90	-4%
Машин тоног төхөөрөмж/компьютер/	392.82	383.51	-9.30	8%
Хуримтлагдсан элэгдэл	-236.42	-114.65	121.77	-2%
Тавилга, аж ахуйн эд хогшил	287.99	286.03	-1.96	6%
Хуримтлагдсан элэгдэл	-126.27	-113.34	12.93	-2%
Зам, гүүрийн байгууламж	133.30	133.30	0.00	3%
Хуримтлагдсан элэгдэл	-32.71	-38.274	-5.56	-1%
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	20.21	20.212	0.00	0%
Бусад үндсэн хөрөнгө	65.54	78.64	13.10	2%
Хуримтлагдсан элэгдэл	-9.03	-9.35	-0.32	0%
Ном	51.86	53.77	1.91	1%
Программ хангамж	4.07	3.63	-0.43	0%
Хуримтлагдсан элэгдэл	-2.96	-0.52	2.44	0%
Бусад биет бус хөрөнгө	50.37	50.07	-0.30	1%

Хуримтлагдсан элэгдэл			0.00	0%
<b>Дүн</b>	<b>5,153.98</b>	<b>5,083.40</b>	<b>-70.58</b>	<b>100%</b>
Засаг даргын тамгын газар	1,163.60	1,192.69	29.09	23.5%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9.12	11.05	1.93	0.2%
Соёлын төв	151.36	144.25	-7.11	2.8%
Сургууль	2,422.89	2,309.76	-113.13	45.4%
Хүн эмнэлэг	860.93	919.17	58.25	18.1%
Цэцэрлэг	491.89	506.47	14.58	10.0%
Эмийн эргэлтийн сан	54.19		-54.19	0.0%
<b>Дүн</b>	<b>5,153.98</b>	<b>5,083.40</b>	<b>-70.58</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Сайхан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 47.3, хандиваар 85.0, балансаас баланст шилжүүлэн авсан 37.7, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг үнийг дахин шинэчилсэн болон бусад 115.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, акталсан 62.7, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг дахин тогтоосон 219.2 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ✚ *Үндсэн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэл зөрүүтэй нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байх батламж мэдээдлийг хангаагүй байна. Тухайлбал: ЭМТ 31.2 сая төгрөг.*
- ✚ *Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлээгүй тайланд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллагаагүй байна. Тухайлбал: ЕБС 9.5 сая төгрөг.*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1.12 сая, эцсийн үлдэгдэл 3.9 сая төгрөг болж, 2.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>				
Байгууллагад төлөх өглөг	0.31	3.63	3.32	99.9%
Хувь хүмүүст төлөх өглөг	0.81	0.23	-0.58	6.2%
<b>Дүн</b>	<b>1.12</b>	<b>3.86</b>	<b>2.74</b>	<b>106.2%</b>
Засаг даргын тамгын газар	0.00	3.30	3.30	0.1%
Соёлын төв	0.00	0.02	0.02	0.0%
Сум хөгжүүлэх сан	0.08	0.08	0.00	0.0%
Хүн эмнэлэг	1.04	0.46	-0.58	0.0%
<b>Дүн</b>	<b>1.12</b>	<b>3.86</b>	<b>2.74</b>	<b>0%</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>				
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	0.00	0.00	0.00	#DIV/0!
<b>Дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>#DIV/0!</b>

Эх сурвалж: Сайхан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 3.3 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн нь ЗДТГ-ын нөөцийн бараа бэлтгэхдээ холбоотой үүссэн өглөг байна

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5832.1 сая, эцсийн үлдэгдэл 5720.8 сая төгрөг болж, 111.4 сая төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,027.36	2,007.29	-20.07	35.09%
Хуримтлагдсан үр дүн	688.55	629.39	-59.16	11.00%
Өмнөх үеийн үр дүн	825.03	669.28	-155.74	11.70%
Тайлант үеийн үр дүн	-136.48	-39.89	96.59	-0.70%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,116.24	3,084.08	-32.16	53.91%
<b>Дүн</b>	<b>5832.15</b>	<b>5720.76</b>	<b>-111.39</b>	<b>100%</b>
<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>				
Засаг даргын тамгын газар	612.751	612.751	0.00	10.71%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2.024	2.024	0.00	0.04%
Хүн эмнэлэг	522.078	522.078	0.00	9.13%
Сургууль	279.51	279.51	0.00	4.89%
Цэцэрлэг	445.384	445.384	0.00	7.79%
Соёлын төв	145.544	145.544	0.00	2.54%
Эмийн эргэлтийн сан	20.07		-20.07	0.00%
<b>Хуримтлагдсан үр дүн</b>				
Орон нутгийн ерөнхий орлого	26.116	59.858	33.74	1.05%
Орон нутгийн хөгжлийн сан	26.403	19.489	-6.91	0.34%
Сум хөгжүүлэх сан	344.327	344.185	-0.14	6.02%
Байгаль хамгаалах сан	3.07	1.736	-1.33	0.03%
Жижиг дунд үйлдвэр	9.092	9.092	0.00	0.16%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9.88	11.835	1.96	0.21%
Эмийн эргэлтийн сан	23.136		-23.14	0.00%
Сургууль	317.773	181.395	-136.38	3.17%
Засаг даргын тамгын газар	137.84	134.448	-3.39	2.35%
Соёлын төв	-24.997	-33.151	-8.15	-0.58%
Цэцэрлэг	-23.44	-3.63	19.81	-0.06%
Хүн эмнэлэг	-160.651	-95.867	64.78	-1.68%
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>				
Сургууль	1917.779	1916.982	-0.80	33.51%
Засаг даргын тамгын газар	488.21	485.20	-3.01	8.48%
Эмийн эргэлтийн сан	28.29		-28.29	0.00%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.40	0.40	0.00	0.01%
Соёлын төв	37.411	37.411	0.00	0.65%
Цэцэрлэг	117.39	117.324	-0.07	2.05%
Хүн эмнэлэг	526.771	526.768	0.00	9.21%
<b>ДҮН</b>	<b>5,832.15</b>	<b>5,720.76</b>	<b>-111.39</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Сайхан сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2007.3 сая төгрөг болж 20.1 сая төгрөгөөр буурсан нь Эмийн эргэлтийн санг хасагдуулснаас шалтгаалжээ. Үүнд:

- Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын 2020 оны 57 дугаар тогтоолоор “Эмийн эргэлтийн сан”-г хасагдуулах шийдвэр гарсан нь ЗГ-ын оруулсан хувь 20.1 сая буюу хуримтлагдсан үр дүнг 23.1 сая, хөрөнгийн дахин үнэлгээ дүнг 28.3 сая төгрөгөөр бууруулан бүртгэсэн байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэлгүй байна.

Хуримтлагдсан үр дүн 629.4 сая төгрөг болж 59.2 сая төгрөгөөр буурсан нь тус сумын СӨБ-ийн 127.0 сая төгрөгийг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд залруулга хийгээгүй байна.

### 3.5.10 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 86.3 сая төгрөгөөр баталж, 121.9 сая төгрөгийг бүрдүүлэн, 35.7 сая төгрөгөөр буюу 41.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +, хэмнэлт -	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>86.26</b>	<b>121.97</b>	<b>35.71</b>	<b>141.4%</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>81.46</b>	<b>114.97</b>	<b>33.51</b>	<b>141.1%</b>
110	Орлогын албан татвар	62.00	99.75	37.75	160.9%
1100	Хувь хүний орлогын албан татвар	62.00	99.75	37.75	160.9%
110002	Үйл ажиллагааны орлого	16.00	23.60	7.60	147.5%
110003	Хөрөнгийн орлого	31.00	45.17	14.17	145.7%
110008	Шууд бус орлого	15.00	30.98	15.98	206.5%
113	Хөрөнгийн албан татвар	4.56	3.29	-1.28	72.0%
113002	Бууны албан татвар	4.56	3.29	-1.28	72.0%
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14.90	11.94	-2.96	80.1%
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6.50	6.50	0.00	100.0%
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4.00	2.46	-1.54	61.5%
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.50	0.56	0.06	112.0%
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.50	2.76	-0.74	79.0%
1181	Газрын төлбөр	0.00	1.20	1.20	#DIV/0!
118101	Газрын төлбөр	0.00	1.20	1.20	#DIV/0!
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	8.40	4.24	-4.16	50.4%
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	8.00	3.82	-4.18	47.8%
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.40	0.42	0.02	103.8%
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4.80</b>	<b>7.01</b>	<b>2.21</b>	<b>145.9%</b>
120	Нийтлэг татварын бус орлого	4.80	7.01	2.21	145.9%
120002	Хүүгийн орлого	3.50	1.33	-2.17	38.0%
120003	Торгуулийн орлого	0.00	4.49	4.49	#DIV/0!
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1.30	1.19	-0.11	91.3%

Татварын орлого 33.5 сая буюу 41.1 хувиар, татварын бус орлого 2.2 сая буюу 45.9 хувиар тус тус давсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

Тайлант хугацаанд төлөвлөгдөөгүй газрын 1.2 сая, торгуулийн орлого 4.5 сая төгрөгийн орлого төвлөрсөн, төлөвлөгдсөн орлогын 6 нэр төрлийн орлого давснаас нийт дүнгээр орлого давсан ч нэр төрлөөр авч үзвэл бууны албан татвар 1.3 сая буюу 28.0 хувь, улсын тэмдэгтийн хураамж 1.5 сая буюу 38.5 хувь, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.7 сая буюу 21.0 хувь, ойн нөөц ашигласны төлбөр 4.2 сая буюу 52.2 хувь, хүүгийн орлого 2.2 сая буюу 62.0 хувь, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.1 сая буюу 8.7 хувиар тус тус тасарсан байна. Энэ нь ковид-19 цар тахал гарсантай холбоотой зарим үйл ажиллагааг тодорхой хугацаанд ажиллаагүй, иргэдийн хөдөлгөөн харьцангуй багассан, хадгаламж нэмэгдээгүй, байгаль хамгаалагч, татварын байцаагч идэвх санаачлаг сул зэргээс орлого тасарсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 447.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- + Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн байна. Тухайлбал: ЭМТ 25.0, ЗДТГ 9.4 сая төгрөг.
- + Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчин зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчин батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Тухайлбал: ИТХ, ЗДТГ
- + ОНХС-ийн журамд нийцээгүй 6.1 сая төгрөгийн зориулалт бус зардалд зарцуулсан байна.
- + Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн нь НББ-ийн холбогдох стандарт, хууль тогтоомжийг мөрдөөгүй байна. Тухайлбал: Цэцэрлэг 28.9, ИТХ, ЭМТ 58.1 сая төгрөг
- + Тендерт шалгараагүй аж ахуйн нэгж байгууллагаас эм, эмийн хэрэгслийн худалдан авалт хийсэн байна. Тухайлбал: ЭМТ 16.5
- + Цалингийн зардлаас нягтлан бодогчид төсөвт батлагдаагүй хавсран ажилласны нэмэгдлийг олгосон байна. Тухайлбал: СӨБ 2.6,
- + Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" , 42.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Тухайлбал: ЭМТ 9.3 сая төгрөг
- + ЭМТ нь түүвэрлэн тулгалт хийхэд тооцоо нийлж бусад харилцсан байгууллагатай тооцоо нийлж 71.6 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- + ЭМГ-аас шилжүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод 5.0 сая төгрөгийн бараа материалыг дутуу бүртгэсэн.
- + Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал: ЕБС 4.1 сая төгрөг
- + Тайлант онд ЗДТГ нь 20340.0 мянган төгрөгийн нөөцийн материал бэлтгэж 11693.9 мянган төгрөгийн зарцуулалт хийгдсэн ч орлого, зарлагын анхан шатны баримтыг батлагдсан маягаар тайлагнаагүй байна. Мөн нөөцийн бараа материал зарж борлуулсан бэлэн мөнгөний тайлан байхгүй, тухай бүрд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй нь НББ-ийн тухай хуулийн 13.5-7, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.12, 8.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

## Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сайхан сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд зааснаар сумын ЗДТГ тайлант онд 1.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 91.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗДТГ	1.30	1.19	0.11	91.3%
<b>ДҮН</b>	<b>1.30</b>	<b>1.19</b>	<b>0.11</b>	<b>91.3%</b>
ЗДТГ-ын байранд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын, халаалт, цэвэр бохир усны төлбөр, түрээс	1.30	1.19	0.11	100%
<b>ДҮН</b>	<b>1.30</b>	<b>1.19</b>	<b>0.11</b>	<b>100%</b>

## Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2020 оны төсвийг ИТХ-ын 2019 оны 10/05 дугаар тогтоолоор орлогыг 2763.7 сая төгрөгөөр баталж ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны 11/07 тоот тогтоолоор 2651.0 буюу 112.7 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Тодотголоор оны эхний үлдэгдэл санхүүжилтийг 48.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, татварын бус орлогыг 2.7, санхүүгийн дэмжлэгийг 11.4, ОНХС-гийн орлогын шилжүүлэг 8.5, тусгай зориулалтын шилжүүлэг 136.3, ТШЗ байгууллагын байр ашиглахтай холбоотой шилжүүлгийг 1.0, соёлын төвийн шилжүүлгийг 0.5 сая төгрөгөөр тус тус бууруулжээ.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2651.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2414.0 сая төгрөгийг урсгал зардалд, 237.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1531.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 720.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 74.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 33.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 197.2 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 95.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1359.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 697.8 сая төгрөг орон нутгийн төсвөөс, 63.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 31.8 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 48.3 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдэл 74.8 сая нийт 1359.6 сая төгрөгийн санхүүжилт буюу 450.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 48.3 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 148.8 сая төгрөгөөр тасарсан нь СХС-аас 157.4 сая төгрөгийн зээл төлөгдөөгүйгээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2172.3 сая төгрөг буюу 81.9 хувьтай байгаа нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан, урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйгээс шалтгаалсан байна. Үүнд:

✚ ЕБС, цэцэрлэгүүдийн халаалтын зардлыг 0.5 сар дутуу халаасан,

- ✚ Урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг хойшлуулсан,
- ✚ Боловсролын байгууллагын хоол хүнс, үдийн цай, дотуур байрны зардал хэмнэгдсэн,

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 16.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 12 төсөл, арга хэмжээнд 82.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 65.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 115.7, дээд шатны төсвийн захирагчаас 16.3, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10.9 нийт 142.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 0.5, НДШ-ийн зардалд 0.06, хангамж бараа материалд 9.4, нормативд зардалд 15.5, Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 11.1, эд хогшил урсгал засварт 35.7, томилолт зочны зардал 16.8, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 3.4, Бараа үйлчилгээний бусад зардалд 56.3, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 0.2, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулж, 3.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 44.2 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал: хэтрэл хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 41.4 сая төгрөгийн 9 арга хэмжээ, СХС-гийн 1.1 сая төгрөгийн зээл, БХС-гийн 1.7 сая төгрөгийн захирамжийг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	-	3	-	-	-	100
Нийт	3	-	3	-	-	-	100

### **3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 тусгай сан 4 байгууллага түүвэрт хамрагдсан, БХС, ЖДҮДС-гууд нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан байна. Тус сангууд нь тусгай сан болон байгууллагын алинд ч хамаардаггүйгээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамрагдлаа.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд ЗДТГ “Хязгаарлалттай”, ЭМТ-д “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 547.3 сая төгрөгийн алдаа, 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 547.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

#### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 41.4 сая төгрөгийн 9 арга хэмжээ, СХС-гийн 1.1 сая төгрөгийн зээл, БХС-гийн 1.7 сая төгрөгийн захирамжийг мэдээлээгүй байна. Төсвийн шууд захирагчид шилэн дансны нэгдсэн системд хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал: ИТХ, ЗДТГ, ЭМТ, Соёлын төв Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1, 3.2, 4.1-д заасныг зөрчсөн, тохиолдсон байх, хэрэгжилт, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

Төвлөрүүлсэн захирагчид 547.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 511.5 сая төгрөгийн алдаа, зөрчил 2.7 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 131.1 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 377.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 20 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### **3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Төсвийн Ерөнхийлөн захирагч төсвийн жилийн дундуур хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө оруулсан өөрчлөлт, хийсэн зохицуулалтынхаа гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх, Харин төсвийн Төвлөрүүлэн захирагч харьяа байгууллагуудынхаа худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг цаг хугацаанд нь дүгнэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **4.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.**

4.1.1 Илрүүлэлт: Тайлант онд нийт 3.3 сая төгрөгийн өглөг, 6.2 сая төгрөгийн авлага нэмэгдсэн, 2012-2019 оны насжилттай СХС, БХС-гийн 165.9 сая төгрөгийн авлага нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр, авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.

4.1.2 Эрсдэл: өр, авлагын насжилт нэмэгдэж, эзэнгүй болох.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах, СХС-гаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зээлдэгчийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, авлагыг бүрэн барагдуулж, төсвийг хохиролгүй болгож, зээлийн гэрээний заалтыг нарийвчлан сангийн журамтай уялдуулан шинэчлэх.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж ажиллах, албан тоот ирүүлсэн.

## **4.2 Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

4.2.1 Илрүүлэлт: Орлогын төлөвлөгөөг 86.3 сая төгрөгөөр баталж, 121.9 сая төгрөгийг бүрдүүлэн, 35.7 сая төгрөгөөр буюу 41.4 хувиар давуулан биелүүлсэн ч бууны албан татвар 28 хувь, улсын тэмдэгтийн хураамж 38.5, хог хаягдлын үйлчилгээний хураамж 21 хувь, байгалийн нөөц ашигласны төлбөр 49.6, ойн нөөц ашигласны төлбөр 52.2, хүүгийн орлого 62 хувиар тус тус тасарсан нь орлогыг дутуу төлөвлөснөөс давж, тооцоо судалгааг сайн хийлгүйгээр төлөвлөснөөс орлого тасарсан байна.

4.2.2 Эрсдэл: Бодиттой төлөвлөөгүйгээс орлого давах тасарснаас гүйцэтгэлд их хэмжээний өөрчлөлт орох, оновчтой бус зарцуулалт хийгдэх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсөв боловсруулахдаа цаг үе, орчин нөхцөл буюу тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж батлуулах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

## **4.3 Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

4.3.1 Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3.2 Эрсдэл: Орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй байх

4.3.3 Өгсөн зөвлөмж: НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

## **4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал.**

4.4.1 Илрүүлэлт: Аудитаар нийт 511.5 сая төгрөгийн 31 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй, үр ашиггүй зарцуулагдах.

4.4.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

#### 4.5 Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.5.1 Илрүүлэлт: Сумын 2020 оны төсвийг батлахдаа “төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үд дүн”-г батлаагүй нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д “Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.3-т “хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх”, 7.5.6-д “аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, дараах зүйлийг тусгана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.5.2 Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, зарцуулалт оновчтой бус байх

4.5.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 22.6.4, Сангийн сайдын 7.1.3, 7.5.6-д заасны дагуу “төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үд дүн”-г тодорхойлж батлуулан, хэрэгжилтийг тооцдог байх.

4.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн


Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

 Д.АНХБАЯР  
 Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



А.СУВДАА